| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ<br/>АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР<br/>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                     | =                            | =                             |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН<br/>ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                               | -                            | -                             |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн<br/>эхний үлдэгдэл</b>                        |                              |                               |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн<br/>эцсийн үлдэгдэл</b>                       |                              |                               |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт                                   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл        | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 20,190,131.82     | 897,748,133.47                         |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00                                   |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 20,190,131.82     | 897,748,133.47                         |
| C07 | Тайлант үеийн үр дүн                       | 0.00                            | 0.00                  | 151,826,921.12    | 151,826,921.12                         |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 172,017,052.94    | 1,049,575,054.59                       |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл        | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 172,017,052.94    | 1,049,575,054.59                       |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 172,017,052.94    | 1,049,575,054.59                       |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт            | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 172,017,052.94    | 1,049,575,054.59                       |
|     | Тайлант үеийн үр дүн                       |                                 |                       | (102,796,241.31)  | (102,796,241.31)                       |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 467,471,147.29                  | 410,086,854.36        | 69,220,811.63     | 946,778,813.28                         |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                |
|-----------------------|--|-----------------------|----------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                       |                |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 352,099,300.00        | 325,065,088.30 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 307,099,300.00        | 305,066,268.30 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 300,104,300.00        | 298,075,678.30 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 178,911,100.00        | 177,130,203.00 |
| 210101                | Үндсэн цалин   | 139,186,600.00        | 137,405,703.00 |
| 210102                | Нэмэгдэл   | 26,551,100.00         | 26,551,100.00  |
| 210104                | Урамшуулал   | 13,173,400.00         | 13,173,400.00  |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 22,880,600.00         | 22,655,963.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 15,006,400.00         | 14,783,000.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 1,978,600.00          | 1,978,600.00   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 1,582,800.00          | 1,582,800.00   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 395,700.00            | 395,700.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 3,917,100.00          | 3,915,863.00   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 22,787,000.00         | 22,786,474.00  |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 2,415,000.00          | 2,414,655.00   |
| 210302                | Түлш, халаалт  | 20,372,000.00         | 20,371,819.00  |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 18,701,500.00         | 18,690,889.30  |
| 210401                | Бичиг хэрэг  | 4,033,000.00          | 4,032,700.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 8,572,500.00          | 8,572,499.30   |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 364,000.00            | 363,460.00     |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 780,000.00            | 780,000.00     |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 4,952,000.00          | 4,942,230.00   |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>  | 6,800,000.00          | 6,799,940.00   |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 2,000,000.00          | 1,999,940.00   |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 4,800,000.00          | 4,800,000.00   |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 27,348,000.00         | 27,347,945.00  |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл  | 2,400,000.00          | 2,400,000.00   |
| 210604                | Урсгал засвар  | 24,948,000.00         | 24,947,945.00  |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>  | 2,216,000.00          | 2,210,000.00   |
| 210702                | Дотоод албан томилолт  | 2,216,000.00          | 2,210,000.00   |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 3,242,800.00          | 3,237,444.00   |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,223,800.00          | 2,223,800.00   |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 200,000.00            | 198,800.00     |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар   | 299,000.00            | 298,176.00     |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 55,000.00             | 55,000.00      |
| 210806                | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 240,000.00            | 240,000.00     |
| 210807                | Газрын төлбөр  | 225,000.00            | 221,668.00     |
| 2109                  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 17,217,300.00         | 17,216,820.00  |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 15,603,300.00         | 15,602,820.00  |
| 210902                | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 1,614,000.00          | 1,614,000.00   |

|             |  |                      |                      |
|-------------|--|----------------------|----------------------|
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                  | 6,995,000.00         | 6,990,590.00         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>            | 6,995,000.00         | 6,990,590.00         |
| 213203      | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж     | 2,000,000.00         | 2,000,000.00         |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,375,000.00         | 3,370,600.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 1,620,000.00         | 1,619,990.00         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                  | <b>45,000,000.00</b> | <b>19,998,820.00</b> |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>               | 45,000,000.00        | 19,998,820.00        |
| 223001      | Бусад хөрөнгө                            | 45,000,000.00        | 19,998,820.00        |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>    | 352,099,300.00       | 324,577,031.30       |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>    | 352,099,300.00       | 324,577,031.30       |
| 122005      | Орон нутгийн төсвөөс                     | 352,099,300.00       | 324,577,031.30       |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Гүйцэтгэл            |
|-------------|--|----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>71,737,946.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>71,737,946.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 71,737,946.00        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 2,609,980.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 630,000.00           |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 1,879,980.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 100,000.00           |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 674,020.00           |
| 210502      | Хоол, хүнс   | 674,020.00           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 9,196,000.00         |
| 210604      | Урсгал засвар  | 9,196,000.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 17,437,017.00        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 17,437,017.00        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 41,820,929.00        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 41,820,929.00        |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | <b>6,183,991.40</b>  |
| 213403      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг                            | 6,183,991.40         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | 77,921,937.40        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 77,921,937.40        |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 12,640,000.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,742,517.91        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 19,539,419.49        |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |                      |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |                      |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |                      |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ний өдрийн 2/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж тасралтгүй сурталчлах алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолтын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 612,846.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,128.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,289.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,735.6 мянган төгрөгөөр буюу 11 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт    |
|-------------------------------------|--------------------|------------------|-------------|
| Эргэлтийн хөрөнгийн дүн             | <b>60,978.2</b>    | <b>41,878.0</b>  | (19,100.2)  |
| Авлага                              | 6,020.5            | 1,296.7          | (4,723.8)   |
| Бараа материал                      | 54,957.8           | 40,581.4         | (14,376.4)  |
| Үндсэн хөрөнгө                      | 988,596.8          | 904,961.3        | (83,635.5)  |
| Нийт хөрөнгийн дүн                  | <b>1,049,575.1</b> | <b>946,839.4</b> | (102,735.6) |
| Нийт өр төлбөр                      | -                  | <b>60.6</b>      | 60.6        |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | <b>1,049,575.1</b> | <b>946,778.8</b> | (102,796.2) |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | <b>1,049,575.1</b> | <b>946,839.4</b> | (102,735.6) |

Бараа материал дансны үлдэгдэл 40,581.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,376.4 мянган төгрөгөөр буурсан нь акталсан бараа материал нөлөөлсөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд хандиваар 12,087.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 21,643.1 мянган төгрөг, шилжүүлэн авсан 360.0 төгрөгийн хөрөнгийг зохих дансанд бүртгэж, 32,293.8 мянган төгрөгийн сайжруулалт хийгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 946,839.4 мянган төгрөг болж 102,735.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 352,099.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 352,099.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээрх дүнгээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 352,099.3 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 352,099.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 92.3 хувийг зарцуулж, 27,522.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 325,065.0 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь хог зөөвөрлөх машин авах 25,000.0 мянган төгрөгийг хил гааль хаагдсантай холбоотой зарцуулаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 45,742.5 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 12,640.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 19,539.4 мянган төгрөг, нийт 77,921.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бичиг хэргийн зардалд 630.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1,880.0 мянган төгрөг, шуудан холбоо интернэтийн зардалд 100.0 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 9,196.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17,437.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 41,821.0 мянган төгрөгийг зарцуулж, 6,184.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 12,000.0 мянган төгрөгийн ухаалаг худаг, төсвийн хөрөнгөөр 22,460.9 мянган төгрөгийн ариун цэврийн өрөөний засвар үйлчилгээ, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 3,000.0 мянган төгрөгийн цагдаагийн сендвичин пост, аймгийн хөрөнгө оруулалтаар 9,943.9 мянган төгрөгийн үүдний засвар, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 19,981.8 мянган төгрөгийн Засаг даргын Тамгын газрын барилгын дээврийн засварын ажлууд хийгдэж бүртгэлд тусгаж, тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтэд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой малчдад туслах 18,858.5 мянган төгрөгийн хандив орж ирснээс малын эрлийн шатахуун, сэг зэм устгах ажлын хөлсөнд 13,722.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,136.0 мянган төгрөгийг сумын Мал хамгаалах санд төвлөрүүлсэн.

Цар тахалтай холбоотой 22,962.4 мянган төгрөгийн хандив орж ирснээс 429.0 мянган төгрөгөөр маяак чанга яригч, 255.0 мянган төгрөгөөр холбооны зориулалтаар гар утас, 22,278.4 мянган төгрөгийг сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хүнс, хамгаалах хэрэгсэл зэрэгт зарцуулжээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 651,085 мянган төгрөгийн 146 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 690.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,076.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,384.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,384.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Завсрын аудитаар тээвэр шатахууны 1,384.0 мянган төгрөгийн түлш халаалтын зардлыг тээвэр шатахууны зардлаар тайлагнасан.

*Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,384.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.*

#### 4.2 Зөвлөмж

##### 1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Завсрын аудитаар агуулахын бүртгэл хөтлөөгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн хөтөлж тайлан гаргаж хэвших

##### 2. Хууль тогтоомжтой холбоотой

2.1. Илрүүлэлт: Ажилтныг томилохдоо эрх зүйн үндэслэлгүй томилсон

2.2. Өгсөн зөвлөмж: тушаал шийдвэр гаргахдаа хууль эрх, зүйн үндэслэлийг зөв тогтоож, эрх бүхий байгууллагаар хянуулах

Дээрх зөвлөмжийн хүрээнд холбогдох 2 зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

##### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д  | Алдаа, зөрчлийн агуулга                                      | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |         |               |     |                 |     |         |     |  |
|--|--|----------------------|-----|-----------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|
|  |  |                      |     | Залруулга |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |  |
|  |  | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |  |
| <b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b> |  |                      |     |           |         |               |     |                 |     |         |     |  |
| <b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>                        |  |                      |     |           |         |               |     |                 |     |         |     |  |
| 1  | Ажилтныг томилохдоо эрх зүйн үндэслэлгүй томилсон            |                      |     |           |         |               |     |                 |     |         | 1   |  |
| 2  | Түлш халаалтын зардлыг тээвэр шатахууны зардлаар тайлагнасан |                      |     | 1         |         |               |     |                 |     |         |     |  |
| 3  | Агуулахын бүртгэл хөтлөөгүй                                  |                      |     |           |         |               |     |                 |     |         | 1   |  |
|  | Нийт зөрчлийн дүн  | 3                    |     | 1         | 1,384.0 |               |     |                 |     |         | 2   |  |